

**ЛэндМН ББСБ ХК болон түүний охин  
компани**  
(Монгол Улсад бүртгэлтэй аж ахуй нэгж)

Нэгтгэсэн санхүүгийн хураангуй тайлан  
2022 оны 12 сарын 31



## НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ХУРААНГУЙ ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

ЛэндМН ББСБ ХК болон түүний охин компанийн хувьцаа эзэмшигчдэд

### Дүгнэлт

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх нэгтгэсэн санхүүгийн байдлын хураангуй тайлан болон тухайн жилийн нэгтгэсэн ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын хураангуй тайлангаас бүрдсэн Нэгтгэсэн санхүүгийн хураангуй тайланг ЛэндМН ББСБ ХК ("Компани") болон түүний охин компани (хамтад нь "Групп" гэх)-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайланд үндэслэн бэлтгэсэн болно.

Бидний дүгнэлтээр хавсралт дахь нэгтгэсэн санхүүгийн хураангуй тайлангууд нь бүх материаллаг зүйлсийн хувьд "Тайлан бэлтгэх үндэслэл" тодруулгад тайлбарласны дагуу Группийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайлантай тохирч байна.

### Нэгтгэсэн санхүүгийн хураангуй тайлан

Энэхүү нэгтгэсэн санхүүгийн хураангуй тайлан нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт ("СТОУС")-ын шаардсан бүх тодруулгыг агуулаагүй болно. Иймд энэхүү нэгтгэсэн санхүүгийн хураангуй тайлан нь Группийн СТОУС-ын дагуу бэлтгэсэн аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайланг орлохгүй.

### Аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайлан ба аудиторын дүгнэлт

Бид 2023 оны 2 дугаар сарын 6-ны өдөр батлагдсан аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайлангуудад зөрчилгүй дүгнэлт өгсөн ба уг дүгнэлтэд доорх хэсэг багтсан.

- Аудитын онцгойлсон асуудал - Аудитын онцгойлсон асуудал нь тухайн жилийн санхүүгийн тайлангийн аудитад бидний мэргэжлийн үнэлэмжээр хамгийн өндөр ач холбогдол бүхий асуудал болох "Харилцагчдад олгосон зээл болон урьдчилганы үнэ цэнийн бууралт" байсан.

### Нэгтгэсэн санхүүгийн хураангуй тайлантай холбоотойгоор удирдлагын хүлээх хариуцлага

Нэгтгэсэн санхүүгийн хураангуй тайланг "Тайлан бэлтгэх үндэслэл" тодруулгад тайлбарласны дагуу бэлтгэх нь Группийн удирдлагын хариуцлага юм.

### Аудиторын хариуцлага

Бидний үүрэг бол шинэчлэгдсэн Аудитын Олон Улсын Стандарт ("АУОС") 810 буюу "Санхүүгийн Хураангуй Тайлангийн Талаар Дүгнэлт Өгөх Гэрээт Ажил"-ын дагуу шаардсан горимуудыг гүйцэтгэж, түүндээ үндэслэн нэгтгэсэн санхүүгийн хураангуй тайланд дүгнэлт өгөх явдал юм.

*Ernst & Young Mongolia Audit LLC*

Эрнст энд Янг Монголия Аудит ХХК  
Мэргэшсэн нягтлан бодогчид

Гарын үсэг зурсан



Мандахбаяр Доржбат  
Партнер

Баталсан



Адриан Чу  
Партнер

Улаанбаатар хот, Монгол Улс  
Огноо: 2023 оны 2 дугаар сарын 6

**ЛэндМН ББСБ ХК болон түүний охин компани**  
**2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн**  
**Нэгтгэсэн Ашиг Алдагдал ба Бусад Дэлгэрэнгүй Орлогын Хураангуй Тайлан**

	<b>2022</b> мян.төг	<b>2021</b> мян.төг
<b>Тасралтгүй үйл ажиллагаа</b>		
Хүү, түүнтэй адилтгах орлого	20,214,948	12,491,742
Хүүний зардал	(3,949,884)	(2,798,653)
<b>Хүү, түүнтэй адилтгах цэвэр орлого</b>	<b>16,265,064</b>	<b>9,693,089</b>
Зээлийн үнэ цэнийн бууралтын буцаалт/(алдагдал)	(1,438,655)	725,556
<b>Үйл ажиллагааны цэвэр орлого</b>	<b>14,826,409</b>	<b>10,418,645</b>
Удирдлагын болон үйл ажиллагааны зардал	(7,656,249)	(5,843,135)
Бусад зардал	(637,914)	(104,039)
<b>Тасралтгүй үйл ажиллагааны орлогын албан татварын өмнөх ашиг</b>	<b>6,532,246</b>	<b>4,471,471</b>
Орлогын албан татварын зардал	(1,007,265)	(469,564)
<b>Тасралтгүй үйл ажиллагааны тайлант жилийн цэвэр ашиг</b>	<b>5,524,981</b>	<b>4,001,907</b>
<b>Зогсоосон үйл ажиллагаа</b>		
Зогсоосон үйл ажиллагааны тайлант үеийн татварын дараах алдагдал	–	(110,996)
<b>Тайлант хугацааны цэвэр ашиг буюу хувьцаа эзэмшигчдэд ногдох нийт дэлгэрэнгүй орлого</b>	<b>5,524,981</b>	<b>3,890,911</b>
<b>Нэгж хувьцаанд ногдох ашиг</b>	<b>MNT</b>	<b>MNT</b>
Компанийн хувьцаа эзэмшигчдийн		
Нэгж хувьцаанд ногдох үндсэн болон шингэрсэн ашиг	7.47	5.17
Тасралтгүй үйл ажиллагаанаас нэгж хувьцаанд ногдох үндсэн болон шингэрсэн ашиг	7.47	5.31

**Тайлан бэлтгэх үндэслэл.** Нэгтгэсэн санхүүгийн хураангуй тайланг СТОУС-ын дагуу бэлтгэсэн Группийн аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан, Нэгтгэсэн ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлангуудыг өөрчлөлгүйгээр хураангуйлан бэлтгэсэн болно.

**ЛэндМН ББСБ ХК болон түүний охин компани  
2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон  
Нэгтгэсэн Санхүүгийн Байдлын Хураангуй Тайлан**

	<b>2022</b>	<b>2021</b>
	<b>мян.төг</b>	<b>мян.төг</b>
<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ</b>		
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	5,217,581	4,903,678
Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаа	64,586,683	31,817,691
Бусад хөрөнгө	768,409	713,788
Урьдчилж төлсөн төлбөр	45,437	18,796
Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх өрийн хэрэглүүр	172,230	–
	<b>70,790,340</b>	<b>37,453,953</b>
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ</b>		
Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаа	4,999,597	608,356
Биет бус хөрөнгө	401,095	447,838
Үндсэн хөрөнгө	373,470	392,047
Ашиглах эрхтэй хөрөнгө	217,592	371,235
Хойшлогдсон татварын хөрөнгө	76,663	33,133
	<b>6,068,417</b>	<b>1,852,609</b>
<b>НИЙТ ХӨРӨНГӨ</b>	<b>76,858,757</b>	<b>39,306,562</b>
<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>		
Зээллэг	33,066,256	6,745,667
Түрээсийн өр төлбөр	285,772	243,626
Бусад өр төлбөр	2,622,414	956,227
Орлогын албан татварын өглөг	815,146	38,221
	<b>36,789,588</b>	<b>7,983,741</b>
<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>		
Зээллэг	15,839,268	11,275,923
Түрээсийн өр төлбөр	–	233,025
	<b>15,839,268</b>	<b>11,508,948</b>
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>52,628,856</b>	<b>19,492,689</b>
<b>ЭЗДИЙН ӨМЧ</b>		
Хувьцаат капитал	10,756,859	10,756,859
Халаасны хувьцаа	(2,337,547)	(2,337,547)
Бусад сан	57,348	57,348
Хуримтлагдсан ашиг	15,753,24	11,337,213
<b>НИЙТ ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>24,229,901</b>	<b>19,813,873</b>
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР БОЛОН ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>76,858,757</b>	<b>39,306,562</b>

**Тайлан бэлтгэх үндэслэл.** Нэгтгэсэн санхүүгийн хураангуй тайланг СТОУС-ын дагуу бэлтгэсэн Группийн аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан, Нэгтгэсэн ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлангуудыг өөрчлөлгүйгээр хураангуйлан бэлтгэсэн болно.